

ХҮННҮ БА ТОБА ХЭЛНИЙ ТАВАН ҮГ

Б.Батсүрэн

Хүннүгийн үед сурвалжид тэмдэглэсэн 5 үгийг, Сяо Цзысянь (489-537) гэдэг хүний зохиосон «Өмнөд Ци улсын бичиг, 47, 57»-д үлдсэн 4 тоба үгтэй харьцуулсанаа толилуулж байна.

Монголчуудын түүхэн орон зайд оршиж байсан нүүдэлчдийн эртний улсуудыг байгуулагч улсын сурвалж үндэс болсон хүн ам, иргэдийн ярилцаж байсан хэлийг судалж шинжилснээс хамгийн сайн судалгаатай нь тоба буюу сяньби (*serbi) хэл гэдгийг бүгд мэднэ. Фань Чжуаню (1930), Л.Лигети (1969, 1970) нарын судалгааны үр дүнд тоба хэл бол хятантай төрөл монгол аялгуу, эртний монгол хэлний байдлыг тусгасан хэл (Сүхбаатар, 1971:94) мөн гэсэн үзэл баримтлал судлаачдын дунд бараг тогтсон гэхэд болно.

Хүннү хэлний хувьд маргаан үргэлжилж байгаа. Гадаадын эрдэмтэд хүннүг түрэг хэлтэн байсан гэдэгт зүгээр л итгэчихсэн, тэгээд үнэн хэмээн улайран зүтгэдэг бол монгол судлаачид хүннүг монгол хэлтэн байсан, монголчуудын өвөг мөн гэдэг. Бодох нэг хэрэг, харин түүхэн баримт үндэслэж хөдөлшгүй нотлохыг зорилго болгогч судалгаа хоцроод гучаад жил болжээ.

Энд харьцуулах үгсийн түүхэнд тэмдэглэгдэж үлдсэн он цаг зөрүүтэй. Хүннүгийн 5 үгийн эхнийх нь МЭӨ 201 онд, сүүлийнх нь МЭӨ 8-МЭ 13 оны үед түүхэнд тэмдэглэгдсэн.

Тобагийн 5 үгийг тэмдэглэсэн сурвалжийг 537 оны орчим зохиосон гэдэг. Харин тус сурвалж 479-502 онд оршин тогтнож байгаад мөхсөн улсын түүхэн баримтыг тэмдэглэсэн. Гэхдээ *тоба* нар наад зах нь Танышихуайн үеэс (136-181) түүхийн тавцанд нэр нь мэдэгдсэн *сэрби/сяньби* аймгийн нэг.

Тэр үед Умард Хүннү улс одоогийн Монгол улсын нутагт оршин тогтносон хэвээр байсныг харгалзан үзвэл харьцуулах гэж буй үгс МЭӨ II зуунаас МЭ II/IV зууны үеийн Төв Ази, Монгол орны оршин суугчдын хэрэглэж, харилцаж байсан хэлний нөхцөл байдлыг бага атугай ч тодруулах байх гэж горьдож байна.

Эдгээр үгийг харьцуулахдаа эхлээд тоба үгийг дараа нь түүнтэй ижил хүннү үгийг авч үзнэ. Гэхдээ хүннү үгийг түүхэнд тэмдэглэгдсэн он цагийн дарааллаар толилуулна. Мөн, өнөөдөр Монгол улсад, утга үсгийн дуудлагыг монгол хэлнээ буулгах нэгдсэн тогтолцоо байхгүй, хоёр ч янзаар буулгаж байна. Эл хоёроос бид Л.Жамсран аругайн толийг (ө.х. П.Кафаровын систем) барьж хаалтнаа *пиньинь* (pinyin)-ийг бичнэ.

1. Чэжицинъ ба Туци

Тобагийн «чэжицинъ» (直勤/慙, zhiqin; Суншу, 72, 1857; 95, 2334; Наньцишу, 47, 819; Будберг, 1936, №10). «Суншу»-ийн 95-р бүлэг, «Наньцишу»-гийн 75-р бүлэгт гардаг тобагийн хааны цусан төрлийн язгууртнуудыг ихэвчлэн *чэжицинъ* (直勤/慙, zhiqin, KD 1220, 389: d'jek-g'jen) гэж тодотгож байна. «Ханхүү» гэсэн утгатай монголын *čigin*-ээс гаралтай орхоны түрэгийн *tigin*, *tdgin* (тигин, тэгин)-ийг орчуулсан Тангийн *тэцинъ* (特勤, teqin) гэдэг

нь илэрхий гэж 1936 онд П.Будберг (1936:172) хэлсэн. П.Будбергийн тайлбарт:

нэг, түрэгийн *тегин* бол *ханхүү* гэсэн утгатай *чигин* гэдэг монгол үгнээс үүссэн, зээлэгдсэн;

хоёрт, тобагийн *чжицин* бол монгол хэлний *чигин* (ханхүү) гэсэн үг мөн;

хэмээх хоёр чухал санал байдаг.

Тобагийн *чжицин* гэдэг үгийг тайлбарлахдаа П.Будберг шведийн эрдэмтэн Б.Карлгрений 1923 оны судалгаа-сэргээлтийг үндэслэжээ. Харин сүүл үеийн судалгаагаар, тухайлбал, С.А.Старостиний 1996 оны цахим толиор бол *чжицин*-ий дундад эртний дуудлага СК. *čik.gin*; А.Шюслерийн 2009 оны толиор хожуу хангийн үеийн дуудлага ЛН. **čik.giən* гэж сэргээгдэх аж (Старостин, 1996:426. 1099/2291; Шюслер, 2009:5-12. 33-5). Сэргээлтээс харвал, *чжицин* гэсэн тоба үг нь гарцаа байхгүй *дигин* эсвэл *джигин* гэсэн язгуур монгол үгийн галиг болох нь улам найдвартай батлагдаж байна. Мөн *чжицин* нь VI-VIII зууны түрэгийн *тегин* гэдэг, угтаа монгол (жужан/нирун) хэлнээс зээлсэн үгнээс үүсээгүй болохыг хангалттай давхар нотлон харуулж байна.

Хүннүгийн «туци» (屠耆, *tuqi*; Ши цзи, 93, 2633; Ши цзи, 110, 2890; Пуллиблэнк, 1962, 257-260). Хүннүгийн хаан ширээ залгамжлагч ханхүү зүүн *туци* ван цол зүүдэг. Түүний дараах эрх мэдэлтэнг мөн баруун *туци* ван гэнэ (Pulleyblank, 1962:257; Пуллиблэнк, 1986:53). Хүннүгээр *сэцэн* гэхийг *туци* гэдэг, их төлөв шаньюйн ууган хөвүүн зүүн *туци* ван болдог ёстой (Ши цзи. VIII:329).

Хүннүгийн *туци* нь *шаньюй*¹ цолтой тун ойролцоо цагт түүхэнд тэмдэглэгдсэн. МЭӨ 201 оны билгийн тооллын өвлийн эхээр (МЭӨ 201.11.7-200.1.4) Модун шаньюй зүүн, баруун сэцэн ванг 10 мянган цэрэгтэй Гуаньфу гэдэг газар руу илгээжээ. Тэнд, Хань угсааг эсэргүүцэн боссон Жао Ли, Ван Хуан, Мань Цючэнь нар цэргээ хуралдуулж байсан юм (Ши цзи. VIII:333; Grand Scribe's Records. VIII:114).

Хүннүгийн *туци* гэдэг үгийг эрт үед яаж дуудаж байсныг Э.Пуллиблэнк анх **daŋ.gē(δ)* гэж сэргээсэн. Тэгээд **daŋ.gē(δ)* нь *тегин*, *тигин* гэдэг түрэг үгийн уугуул хэлбэр байх ёстой гээд *тегин*, *тигин* нь *-n* болон олон тооны *-t* төгсгөлтэй байгаа нь түрэг хэлнээ монгол төрлийн ямар нэг хэлээр (Mongolian type of language) дамжиж зээлэгдсэнийг гэрчилж байна гэж дүгнэсэн (1962:257-258; 1986:53). Э.Пуллиблэнкийн өгүүлэл олны хүртээл болж байсан цагт дэлхий даяараа шахуу *тегин*, *тигин* гэдэг үгийг шууд түрэг үг гэж хар аяндаа боддог байсан цаг. Харин ойрын хорь гучаад жилийн судалгааг үндэслэвэл *тегин* нь монгол хэлнээс түрэг хэлэнд зээлсэн үг гэдэг нь улам бүр нотлогдсоор байгаа билээ.

Жэнжан Шанфан, С.А.Старостин, А.Шюслер нарын толиор *туци*-гийн эртний дуудлага нь ОС. **da.gri*; түрүү ханьгийн үеийн дуудлага нь ЗХ. **dā.grjəj*; хожуу ханьгийн үеийн дуудлага нь ЛН. **da.gi* гэж сэргээгдэж байна (Жэнжан, 2003:559, 566; Старостин, 1996:802, 722; Шюслер, 2009:1-38, 26-6).

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн аман аялгуу судлах шинжилгээний ангийн ахлагч Д.Цэнд 1967 онд Булган аймагт ажиллахдаа “нутгийн хөгшчүүлээс олж сонссоноо газар дээр нь шалгаж ... мэдээлсний мөрөөр” М.Шинэхүү 1972 онд очиж уг газрыг шалгаж бичээсийг илрүүлж анхны зураг үйлдсэн төдийгүй, V-VI зууны *жужан* (нирун) нарт холбогдох магадлалтай “брахма” бичиг гэж тогтоосон (1974:206-208) дурсгалыг орчин цагт шинжилсэн судалгаагаар бол монгол хэлэнд холбогдох анхны түүхэн баримт 1224 онд бус харин 600 жилийн өмнө холбогдох болсон. Тэрхүү дурсгалын эхний мөрд буй “1. *biti nār kaγan digin šini-n bodisatva töröḥ(ö)* ... бид нар хаан, *дигин* шин-ийн бодисатва төрөх” (Хурцбаатар, 2019:125-126) гэдэг үг дундах *дигин* бол хүннүгийн *туци* гэдэг үгийн язгуур хэлбэр болохыг гэрчилж байгаа чухал баримт билээ. Мөн хааны ургийнхан зүүдэг, *ханхүү* гэсэн утгатай хүннүгийн *туци* (**dā.gi<n>*) гэдэг үг *дигин* (*digin*) гэсэн хэлбэрээр нирунд уламжлагдсаныг

¹ МЭӨ. 265-245 оны үед анх утга үсгийн сурвалжид тэмдэглэгджээ.

дээрх баримт гэрчилж байна.

Ханхүү гэсэн утгатай *ддгин/дигин* (туци) гэдэг хүннү (монгол) үг, эртний монгол хэлний байдлыг тусгасан гэж Лигетийн тодорхойлсон сяньби хэлний тоба аялгуунд *дигин* ~ [᠋]*жигин* ~ *д_жигин* (dik.giən ; dik.gin), харин нирунд *дигин* (digin) гэх хэлбэртэй хэрэглэгдэж байжээ.

Хүннүгийн *дигин/дэгин* (туци) бол монгол хэлний үг гэдэг нь «Монголын нууц товчоон, § 239»-н баримтаар нотлогдоно. Тэнд дурдсанаар, Зүчи (Жочи) “гэртээс сая гарч одсон газраа мөр сайтай явж ... ойн иргэнийг өлзийтэй оруулж” ирэхдээ Киргиз хүрчээ. Нутгийн зарим ноён *дигин* гэдэг цолтой байжээ. Түрэг хэлний *тегин*-тэй ижил утгатай ч, монголчуудад өөрсдийн гэсэн эртний, хүчтэй уламжлал байсан учраас л киргиз ноёд *тегин* гэсэн хэлбэрийг бус харин *дигин* гэсэн язгуур монгол үгийг зээлжээ гэж үзэж болох л юм.

2. Цихайчжэнь ба Сиюйцянь

Тобагийн «цихайчжэнь» (契害真, qihaiizhen; Наньцишу, 57, 985; Ligeti, 1970, 6᠐). Эртний дуудлагыг нь Л.Лигети, *k'iei.ɣvi.t'šjēn гэж сэргээгээд qityaičīn «алуурч» гэж тайлаад, энэ үг «Монголын нууц товчоон»-д kidu'ači (§§ 181, 6202²) гэж тэмдэглэгдсэн гэжээ (1970:237).

Л.Лигетийн саналыг монголын эрдэмтэн А.Лувсандэндэв 1978 оны өгүүлэлдээ дэмжжээ (2002:128-135). Тэр, *цихайчжэнь*-ийг түрэг үг гэсэн эрдэмтдийн санал, таамаглал огт үндэслэлгүйг нотолсон юм. Мөн «цаазлагч» гэсэн утгатай монгол хэлний уул үгийн тоба аялгууных, «Монголын нууц товчоон» дахь ижил утгатай үгээс бүтэц өөрийг харуулжээ. Өөрөөр хэлбэл, «Монголын нууц товчоон»-ы kidu'ači > kidu- + ɣa + -či, харин «Наньцишу»-д тэмдэглэсэн тобагийн qityaičīn > qit- + ɣa + -i + -či + -n гэдэг загвараар бүтсэн гэж үзжээ.

Л.Лигетийн судалгаанаас хойш утга үсгийн эрт, дундад үеийн дуудлагын сэргээлтийн чиглэлээр олон судалгаа нийтлэгдсэн. Тэдний нэг болох 400 оны үеийн Хэси хонгилын дуудлагыг сэргээсэн Саус Коблины толиор бол *цихайчжэнь* ONW. *khei.ɣai.tšin, III-VI зууны дуудлагыг сэргээсэн С.А.Старостиний судалгаагаар ПДК. *khiēs.ɣās.čīn гэж сэргээгдэнэ. Энэ хоёрыг харвал «хядах» гэсэн үгтэй төрөлсөх бус харин *гэсгээж цээрлүүлэх, гэсгээн шийтгэхийн* «гэсгээх»-тэй төстэй *khēs.ɣās.čīn = kes.ges.čīn гэсэн үг шиг харагдаж байна. Түүний дээр «Монголын нууц товчоон» дахь *хядаач* (kidu'ači) гэсэн үг бол Тоорил хан ах, дүүсээ хядаж устгасныг л зааж байгаа хэрэг, ажил мэргэжилтэй холбоотой үг биш байх. Тэмүжин Чингис ханаас өмнө хамаг монголын зургаа дахь хан Хотул бас Тоорилыг ингэж тодорхойлж байсан нь «Судрын чуулган»-д үлдсэн (Сборник летописей, Том I, кн. 1:130).

Тэгэхээр *цихайчжэнь* гэсэн тоба үг бол *гэсгээгчин* (WM. gesegügegčīn) гэсэн үгийн галиг бололтой.

Шинэ санал биш, В.Эберхард 1942 онд *цихайчжэнь* гэсэн тоба үгийг kāsägčīn (Scharfrichter) гэж үзжээ (Ligeti, 1970:303 n.64). Гэхдээ заавал цаазын ял гүйцэтгэгч байх албагүй, төрийн хууль цааз зөрчигчдийг гэсгээн цээрлүүлэх үүрэгтэнг ийн нэрлэх магадлалтай.

Хүннүгийн «сиюйцянь» (係零淺, xiuyuqian; Ши цзи, 110, 2896). Юэчжиг ялаад харьяат аймаг, улсуудыг нь эрхшээлдээ оруулсан Модун шаньюйгаас ханьгийн хаанд МЭӨ 176 онд илгээсэн захидалд дурдах тус үгийн өмнө байрлах *ланчжун* (郎中) гэдэг үгээс болж эрдэмтэд хүний нэр болгож орчуулж байжээ.

«Хань улсын бичиг»-ийн Хүннүгийн бүлгийг орчуулсан А.Вайли “the envoy Ke Ноо-тseen” (1874:416) гэж, «Түүхийн тэмдэглэл»-ийн Хүннүгийн бүлгийг орчуулсан Э.Паркер “my secretary Hihuts'ien” (1892:14), де Гро/де Грот „He-u-tsiēn, einen Intendanten des inneren Hofes” (1921:77), Б.Уатсон “my palace attendant His-hu-ch'ien” (1961:168), В.С.Таскин “телохранитель Сихуцянь” (1968:43), Р.В.Вяткин нар “ланчжун Сиюйцянь” (2002:333),

² Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн үгийг заахдаа Игорь де Рахевильцийн системийг хэрэглэв.

Э.Гил “Palace Attendant His-yü-ch’ien” (2010:272) гэж тус тус орчуулжээ. Түүнчлэн, «Түүхийн тэмдэглэл»-ийн Сиюйцян-ийг Б.Уатсон, В.С.Таскин нар «Хань улсын бичиг»-ийг дагаж Сихуцянь болгож өөрчилжээ.

У.Бакстер, Л.Сагар нарын судалгаагаар *сиюйцян* гэсэн үг эрт цагт ОС. *kʰek·s.gʷa. tsʰen гэсэн дуудлагатай байсан мэт. Харин *сиюйцян* гэсэн үгийн өмнө байрлах *ланчжун*-ыг монгол хэлнээ «шийтгэгч түшмэл» (Хятад-Монгол толь, 2007:833) хэмээн орчуулдаг бололтой. Тэгэхээр, *ланчжун* бол *сиюйцян* гэсэн хүннү үгийн хятад орчуулга бөгөөд ардаа байрлах хүннү үгийн утгыг заасан гэж үзлээ. Тухайн санал бодит байдалд дөхөж чадсан бол ОС. *kʰek·s.gʷa.tsʰen нь үнэн хэрэгтээ *keks.gwa.tsen буюу *гэсгээгчин* хэмээх үгийн галиг байх магадлалтай.

Шийтгэгч түшмэл гэсэн утгатай хүннү ба тоба үг нь орчин цагийн монгол хэлний *гэсгээгч* (gesegügegč) гэсэн үгтэй холбоотой бололтой. Хүннүгийн *сиюйцян* нь *keks.gwa. tsen гэж сэргээгдэх бол тобагийн *цихайчжэнь* нь kes.ges.čín гэсэн хэлбэрийг харуулж байна.

3. Шэкуйчжэнь ба Жирохоу

Тобагийн «шэкуйчжэнь» (折潰真, shekuizhen; Наньцишу, 57, 985; Будберг, 1936, №18). Уг үгийн утгын хятад тайлбарын К.Шираторийн орчуулгыг А.Будберг шүүмжилжээ. Түүний бичсэнээс үзвэл тобачууд, эзнийхээ шийтгэл, хүсэлтийг уламжилдаг хүнийг *шэкуйчжэнь* гэж нэрлэдэг байсан бололтой, албан тушаал болох нь эргэлзээгүй. Улмаар *шэкуйчжэнь*-ийг тоба нэр томьёо мөн бөгөөд монгол хэлний *заргач* (*jaɣaɕi ~ *jaɣuɕi) хэмээх үг гэж А.Будберг дүгнэжээ (1936:174).

Канадын хятад судлаач Э.Пуллиблэнкийн 1991 оны толиор бол *шэкуйчжэнь* нь дундад эрт үед EMC. dziat.ɣwəʰ.tein гэсэн дуудлагатай байжээ (1991:278, 178, 401). Тэртээ, 1936 онд А.Будбергийн хэлсэнчлэн тобагийн *шэкуйчжэнь* бол монгол хэлний EMC. dziat.ɣwəʰ.tein < *jaɣ.ɣwə.čín → *jaɣuɕín гэсэн үг болох гарцаагүй бололтой.

Хүннүгийн «жирохоу» (籍若侯, jiruohou; Шицзи, 111, 2928). Билгийн тооллын морь жилийн хаврын хоёр сард (МЭӨ 123.3.24-4.22) ханьгийн жанжин Хо Цюйбин 800 хөнгөн морьт цэргээр, *шаньюйн* авга *жирохоу* (籍若侯, jiruohou) Чань-ий захирсан хүннүгийн нэг *бүлэг* (овог)-ийг довтолж түүнийг алахад, хүү Логуби нь *сянго*, *данху* нарын доорх түшмэд, ард иргэд нийлсэн 2028 хүнээ дагуулан бууж өгчээ (Ши цзи, IX:32; Grand Scribe’s Records, IX:325-326).

Тус мэдээнд гарах *жирохоу*-г албан тушаалын нэр гэж үзэж байна. А.Шюсслер, У.Бакстер, Л.Сагар нарын толиор *жирохоу*-г эрт цагт LH. *dziak.ɳak.go, OCM. *dzak.nak. gʰ; ОС. *dzak.nak.gʰo гэж дуудаж байсан бололтой (Шюсслер, 2009:2-32, 2-30, 10-6; Бакстер, Сагар, 2011:57, 109). Үүнийг үндэслэвэл, хүннүгийн түшмэлийн бас нэг цол - *жирохоу* нь хожмын *заргач* (*dzak.nak.gʰo < *dzarkagč) гэсэн үг хэмээн тайлж болох юм.

4. Бидэчжэнь ба Бичэци

Тобагийн «бидэчжэнь» (比德真, bidezhen; Наньцишу, 57, 985; Ligeti, 1970, 5ө). Л.Лигети тус үгийг тайлбархдаа “үүнд түрэг хэлний тайлбар ямар ч хамаагүй” гэж анхааруулжээ. Орчин цагт *бидэчжэнь* гэж дуудаж буй, эртний тоба үгийн галигийг pi-tö-tchen хэмээн уншиж, эртний дуудлагыг нь *bʰji.tək.tʰšjēn гэж сэргээсэн Л.Лигети *бичээч* буюу *bitekčín хэмээн үзжээ (1970:236-237).

Э.Пуллиблэнкийн толиор *бидэчжэнь*-ийг дундад эртний үед EMC bjiʰ.tək.tein гэж дуудаж байжээ (Лигети, 1970:236-237). Чухам, EMC bjiʰ.tək.tein < *bi.te.čín ~ *bi.tek.čín болох нь гарцаагүй ажээ.

Хүннүгийн «бичэци» (比車耆, bicheqi; Ши цзи, 111, 2936). Хүннүд холбогдох үгүүд дотор ямар ч эргэлзээгүй *бичээч* гэсэн үг гэж үздэг *бичэци* гэх албан тушаалтны талаарх

мэдээ МЭӨ 119 оны Хо Цюйбиний довтолгооны тухай өгүүлэх ханьгийн түүхэнд үлджээ. МЭӨ 119 оны хавар шаньюй дорно зүгт нүүсэн гэх мэдээг олзны хүннү хүнээс олж сонссон Хо Цюйбин 50 мянган морьт цэрэг, хэдэн зуун мянган явган цэрэг, их хэмжээний ачаа хөсөгтэй Дай хотоос гарч умард руу мянган ли (Хүннүгийн бүлэгт хоёр мянган ли гэдэг) зам туулав. Түүнийг буцаж ирэхэд нь ханьгийн хааны хэлсэн үгээр бол Хо Цюйбин биечлэн *хуньюй/хунье* (葷粥, хуну) аймгийн цэргийг авч ачаа хөсгөө хөнгөлөн их цөл туулж Хочжанцюй (獲章渠, huozhangqu)-г гэтлээд хүннүг довтолж *бичэци* (比車耆, bicheqi)-г алжээ (Ши цзи. IX:36, 38; Grand Scribe's Records. IX:335, 337-338; Батсүрэн. 2016:23).

Эрт цагт бичэци-г LH. *bi.tshja.gi ~ *bi.tshja.tsi гэж дуудаж байжээ (Шюсслер. 2009:26-38, 1-10. 26-6). Энэхүү сэргээлтийг үндэслэвэл *бичэци* нь *бичиг* (*bi.tshja.gi) эсвэл *бичээч* (*bi.tshja.tsi) гэсэн үгийн тэмдэглэгээ болох нь маргаангүй мэт. Хүннүгийн *бичэци* (*bi.tshja.tsi < *bičjäči) нь мөн монгол хэлний нэг болох табгачийн *бидэчжэнь* (比德眞, bidezhen) буюу Л.Лигетийн *bitekčün = битэгчин (1970:236) гэсэн сэргээлтээс ялгаатай байгаа нь эрт цагт монгол хэлтнүүд хэдийнээ тус тусын аялгуунд хуваагдсан болохыг нотолж буй хөдөлшгүй гэрчийн нэг мөн гэж үзэж болох юм.

5. Кэхань ба Хуюй

Тобагийн «кэхань» (可汗, kehan; Будберг, 1936, №9). Тобагийн ноёрхлын үед зохиогдсон Мулань (木蘭, mulan, ONW. *mok.lan (Caсc Коблин. 1994:1143. 0617) < *mo.lar ~ *bo.lar)-ий алдарт дуунд эзэн хаанаа *кэхань* (可汗, kehan) гэдэг хэмээн бичсэн А.Будберг, *хаан* цолыг орхоны түрэгүүд түрүү үеийн жужан (нирун) нараас, тэд харин тоба юм уу муюн нараас авсан гэж үзжээ (1936:171-172).

Жужан буюу нирунчууд *хаан* цолыг тоба, муюн нарын сяньби/сэрби аймгаас авсан хэмээх А.Будбергийн 1936 оны санал хуучирчээ. Яагаад гэвэл, жужан/нирун нарын багтаж явсан Хүннү улсад тус цол анх үзэгдсэн гэж Э.Пуллиблэнк 1962 оны өгүүлэлдээ бичсэн билээ. Харин сяньбийн бүлэгт багтах аймгуудаас хамгийн анх *хаан* цол зүүсэн нь цифу/көбүн (ki-fou «fils, garçon» < mong. *köbö[n] [forme dialectale bouriate] (Ligeti, 1970:276 n.20)) аймгийн эзэн гэж болно. Барагцаалбал III зууны хорь-гучаас - тавь-жараад оны үед амьдарч байсан Хэгань-ийг «тодо мохэ, 託鐸莫何, tuoduo mohe < *žik.tai/jigtei abaga (Ligeti, 1970:276 n.20)) хаан хэмээн өргөмжилжээ. Сонирхолтой нь цифугийн 3 аймаг анх говийн араас Иньшань (Даланхарын нуруу) ууланд нүүж очсон юм (Таскин. 1984:89-90). Өөрөөр хэлбэл, хүннүгийн нутгаас нүүж очсон байх магадлалтай. Ч.Амартүвшин нар Өмнөговийн Ханбогд сумын Булан тойром гэдэг газраас 2010 онд сяньби боловч зарим талаар сонгодог гэх сяньби булшнаас ялгаатай булш илрүүлжээ. Радиокарбоны шинжилгээ нь 130-260 он (66 %) эсвэл 80-340 онд (95 %) холбогдоно гэж гарчээ (Амартүвшин нар. 2015:372-379).

Сурвалжийн мэдээ, археологийн дурсгалын судалгаа хоёрыг харьцуулж үзвэл, говийн араас нүүж Иньшань-д очсон цифу нарт Өмнөговийн Булан тойромын булш холбогдох юм биш биз гэсэн таамаг дэвшүүлж болохоор!

Хүннүгийн «хуюй» (護于, huу; Ханьшу, 946, 3827; Пуллиблэнк, 1962, 260-262). МЭӨ 8 онд хүннүгийн хаан ширээнд суусан Нанчжиясы *шаньюйг* «Учжулю жоти» гэж өргөмжилжээ. Тэрээр 21 жил хаан суугаад МЭ 13 онд нас барсан юм. Гэтэл, түүний үед хэд хэдэн зүүн *сэцэн ван* дараалан үхсэн гэдэг. Тэгээд *туци/сэцэн* гэх цол хар хэл ам дагуулж байж гэж Нанчжиясы *шаньюй* үзээд зүүн *туци ван* цолыг «хуюй» гэдэг цолоор халж, түүнийг (ө.х. хуюй-г) хамгийн тэргүүн зэрэгт эрэмбэлжээ. МЭӨ 8 оноос МЭ 13 оны хооронд нас барсан зүүн *сэцэн вангууд* гол төлөв түүний дүү нар байсан бололтой. Нанчжиясы *шаньюй* шинэ цол бий болгонгуутаа ууган хүүгээ *хуюй ван* болгож хаан ширээ өвлүүлэх гэж зорьжээ. Гэвч түүнийг нас барсаны дараа МЭ 13 онд хүннүгийн *шаньюй* болсон дүү Сянь нь *хуюй*-гийн эрэмбийг бууруулж, зүүн *сэцэн вангийн* дараа орохоор болгожээ.

Чухамхүү энэ - хуюй цолыг Э.Пуллиблэнк судалж анх удаа *хаан* гэсэн үг байна гэж үзсэн юм. Тэр 1962 онд тус галиг-үгийн тэр цагийн дуудлага нь *hwaх-hwāh байсан гээд *хаан* (qayan) гэсэн үг хэмээн харахыг хүсэж байна, мөн *хаан* гэх утга агуулж байсан болов уу гэжээ. Улмаар энэ сэргээлт, өөрөөр хэлбэл *hwaх-hwāh-аас уул үгийн язгуур хэлбэр *γ^waγ^wā эсвэл *GaGā байсан байх хэмээн үзсэн билээ (1962:261; 1986:57). Гэхдээ Э.Пуллиблэнк уг үгийг буюу *γ^waγ^wā/*GaGā-г кет хэлний үг гэж тайлбарласан юм. Эл саналыг орчин цагт А.Вовин их дэмждэг. Гэтэл 2016 оны судалгааг үндэслэвэл, кет угсаатан нь 3400-3250/2900 жилийн өмнөх Карасукийн соёл, болон түүнийг залгаж оршиж байсан түрүү төмрийн үеийн дурсгалыг (2900-1500 жил) үлдээгч нартай ижил ген-тэй болох нь батлагджээ. Мөн «Окуневийн соёлыг» үлдээгчдийн ген *кетүүдэд* өвлөгдсөн гэдэг (<https://www.nature.com/articles/srep20768>; Балановский, 2015:274-276). Харин монголын археологичид, антропологичдын судалгаагаар бол хүннүүд Дөрвөлжин булшны соёлыг үлдээгч нараас гаралтай гэгддэг. Тиймээс, *хаан* (*γ^waγ^wā/*GaGā) гэдэг үгийг *кет-енисейн* хэлний үг гэж тайлбарлах нь судалгааны мухар чиглэл гэлтэй.

Хаан гэх үгийн анхны галиг гэх *хуйю*-гийн хожуу ханьгийн дуудлага нь LH. *γua.wa болно. Тэр цагийн нэг жишээ татахад төгсгөлийн - *wa-аар ханьгийн үеийн Хотан (Khotan) гэдэг үгийн язгуур болох Hvadna-гийн hva-г галиглаж байжээ (Шюсслер, 2009:2-8, 1-23). Тэгэхээр LH. *γua.wa нь үндсэндээ *γua.hva байж болох нь. Харин С.А.Старостиний толиор бол баруун ханьгийн үеийн дуудлага нь ЗХ. *whāk.wa юм байна (1996:1585, 18). Баруун ханьгийн *whāk.wa гэх дуудлагаас *hāk.ha → *hākha<n> гэсэн язгуур үг байжээ хэмээн төсөөлж болох юм.

Хамгийн гол нь эдгээр сэргээлтийн аль аль нь Э.Пуллиблэнкийн судалгаа зөв болохыг харуулж байна. Тиймээс монгол хэлтэн нар хэрэглэж байсан, түрэгүүд зээлсэн *хаан* (хуюй ба кэхань) гэх цол нь анх хүннү нарт байсан хэмээх түүний дүгнэлт зөв гэж дэмжиж байна.

Товч дүгнэлт

Эхлээд та бүхэнд толилуулсан, хүннү-тобагийн түүхэнд үлдсэн тус тусын таван үгийн талаарх саналаа хураангуйлж, хүснэгтээр харуулъя. Эдгээр арван үгээс хүннүгийн хоёр үгийг (сиюйцянь ба жирохоу) анх удаа тайлбарлаж байна.

Хүннү (МЭӨ IV - МЭ III зуун)			Тоба (МЭ I/II - VI зуун)	
туци 屠耆, tuqi	LH. *dā.gi<n> ЗХ. *dā.gj<n>	дигин/чигин (ханхүү)	СК. dik.gin LH. *dik.giən	чжицинъ 直勤/懃, zhiqin
сиюйцянъ 係雫淺, xiyuqian	OC. *k ^h ek.s.g ^w a.ts ^h en	гэсгээгч (WM. gesegügegčin)	ONW. *khei.γai.tsin ПДК. *khiēs.γās.čin	цихайчжэнь 契害真, qihaizhen
жирохоу 籍若侯, jiruohou	LH. *dziak.nak.go OC. *dzak.nak.g ^o	заргач (WM. jarγuči)	EMC. dziat.γwə ^h .tein	шэкуйчжэнь 折潰真, shekuizhen
бичэци 比車耆, bicheqi	LH. *bi.ts ^h ja.gi ~ *bi.ts ^h ja.tsi	бичээч (WM. bičigeči)	EMC bji ^h .tək.tein	бидэчжэнь 比德真, bidezhen
хуюй 護于, huyu	LH. *γua.wa~*γua.hva ЗХ. *whāk.wa~*hāk.ha	хаан (WM. qayan)	СК. khv.γvn	кэхань 可汗, kehan

Сяньбийн гол аймгуудын нэг тоба аймгийг монгол хэлтэн байсан гэдэгт өдгөө эргэлзэх шалтгаан байхгүй. Тиймээс тоба үгүүдтэй ижил утгатай гэж үзсэн хүннүгийн таван үгийн харьцуулалтаас үзвэл хүннү нь «монгол хэлтэн», «монгол угсаатай» байсан гэдэг манай эрдэмтдийн санал үнэний хувьтай болох нь харагдаж байна.

Түүнчлэн бид, тобагийн *цихайчжэнь* гэдэг үг нь *хядгайчин* бус харин *гэсгээч* гэсэн монгол үгийн галиг гэсэн В.Эберхардын 1942 оны саналыг дэмжив. Гэхдээ, *цихайчжэнь* гэсэн тоба үгийг *käsägčīn бус харин *khēs.γās.čīn → *kes.ges.čīn гэх хэлбэртэй гэж үзэж байна.

МЭӨ 176, 123 онд хятад сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн *сиюйцянь*, *жирохоу* гэсэн хоёр хүннү үгийг анх удаа тайлбарлаж судалгааны эргэлтэнд оруулж байгаа бөгөөд монгол хэлний *гэсгээч* (сиюйцянь - *kʰek·s.gʷa.tsʰen < *keks.gwa.tsen), *заргач* (жирохоу - *dzak.nak.gʰo < *dzarkagč) гэсэн үгс хэмээн таамаглаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Сборник летописей.** Том I, кн. 1 - Рашид-ад-дин. Сборник летописей. Том I, кн. 1. Перевод с персидского Л.А.Хетагурова, ред. и прим. А.А.Семенова. Изд-во. АН СССР.
- Таскин В.С.** 1968. Материалы по истории сюнну (по китайским источникам). Предисловие, перевод и примечания. Изд-во «Наука», ГРВЛ.
- Таскин В.С.** 1984. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Введение, перевод и комментарии. Изд-во «Наука», ГРВЛ.
- Ши цзи.** 2002. Сыма Цянь. Исторические записки (Ши цзи). Том VIII. Перевод с китайского Р.В.Вяткина и А.М.Карапетьянца, комментарий Р.В.Вяткина, А.Р.Вяткина и А.М.Карапетьянца, вступительная статья Р.В.Вяткина. Изд. фирма «Восточная литература» РАН.
- Ши цзи.** 2010. Сыма Цянь. Исторические записки (Ши цзи). Том IX. Перевод с китайского, комментарий под редакцией А.Р.Вяткина, Вступительная статья А.Р.Вяткина. Изд. фирма «Восточная литература» РАН., М.,
- De Groot J.J.M.** 1921. Die Hunnen der Vorchristlichen Zeit Chinesische urkunden zur Geschichte Asiens. Erster teil. Ibersetzt und Erldutert. Berlin und Leipzig.
- Grand Scribe's Records.** 2008. Emmerich, Reinhard. Hann Hsin and Lu Wan. Memoirs 33 – The Grand Scribe's Records. Volume VIII. The Memoirs of Han China, Part I by Ssu-ma Ch'ien. Edited by William H.Nienhauser, Jr. IUP., Bloomington & Indianapolis. pp. 107-137.
- Grand Scribe's Records.** 2010. Giele, Enno. The Hsiung-nu. Memoirs 50 - The Grand Scribe's Records. Volume IX. The Memoirs of Han China, Part II by Ssu-ma Ch'ien. Edited by William H.Nienhauser, Jr. IUP., Bloomington & Indianapolis. pp. 237-310.
- Parker E.** 1892. The Turko-Skythian tribes - The China Review. Vol. XX, No 1. pp. 1-24.
- Watson B.** 1961. Records of the Grand Historian of China. Translated from the Shih chi of Ssu-ma Ch'ien. Vol. II: The age of Emperor Wu 140 to circa 100 B.C. CUP., New York and London.
- Wylie A.** 1874. History of the Heung-noo in their Relations with China. Translated from the Tseenghan-shoo. Book 94. ets. - Journal of the Anthropological Institute. Vol. III. London. pp. 401-451.
- Амартүвшин нар.** 2015. Амартүвшин Ч., Батзориг О. *Булан тойромын були* - СА. Том. XXXV, Fasc. 24. Уб., х. 372-379.
- Балановский О.П.** 2015. Генофонд Европы.
- Батсүрэн Б.** 2016. Ухуань (Авар) ба Сяньби (Сэрби). Уб.
- Лигети Л.** 1970. *Табгач хэл сяньбийн нэгэн аялгуу болох нь*. ХЗС. Том. VII, Fasc. 9. ШУАХ., Уб., х. 227-244.

- Лувсандэндэв А.** 2002. *К расшифровке табгачского слово k'i-hai-tchen*. А.Лувсандэндэв. Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь. Уб., Онги бээс, х.128-135.
- Пуллблэнк Э.Д.** 1986. Язык сюнну. Зарубежная тюркология. Вып. I. Древние тюркские языки и литература. Изд-во “Наука”. ГРВЛ., стр. 29-70.
- Сүхбаатар Г.** 1971. *Сяньби нарын угсаа гарал, соёл, аж ахуй, нийгмийн байгуулал* (Нэн эртнээс МЭ IV зуун). ШУАХ., Уб.
- Хурцбаатар Л.** 2019. *1400 жилийн өмнөх өвөг монгол хэл. Хүйс толгойн бичээс (HT1)-ийн судлал*. Elias Verlag ImoFiF e.V. Cologne.
- Шинэхүү М.** 1974. *Шинэ бичээс олдлоо*. SH. Том. X. Уб., х. 206-208.
- Boodberg, Peter A.** 1936. *The Language of the T'o-pa Wei*. HJAS. Vol. 1. No 2. 1936. pp. 167-185.
- Pavel Flegontov, Piya Changmai нар.** *Genomic study of the Ket: a Paleo-Eskimo-related ethnic group with significant ancient North Eurasian ancestry*. <https://www.nature.com/articles/srep20768>)
- Ligeti L.** 1970. *Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi*. Mongolian Studies. Edited by L.Ligeti. Gruner. Amsterdam, pp. 265-308.
- Pulleyblank, Edwin G.** 1962. *The Consonantal System of Old Chinese. Part II, Appendix. The Hsiung-nu Language*. AM. New Series. Vol. IX, pp. 239-265.
- Pulleyblank, Edwin G.** 1991. *Lexicon of Reconstructed Pronunciation in Early Middle Chinese, Late Middle Chinese, and Early Mandarin*. UBC Press. Vancouver.
- Coblin, South W.** 1994. *A Compendium of Phonetics in Northwest Chinese* JCL. Monograph Series No. 7.
- Старостин.** 1996. *Китайские иероглифы*. Составитель С.А.Старостин (цахим PDF толь).
- Schuessler A.** 2009. *Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Recensa*. UH Press. Honolulu.
- Baxter, W. and L.Sagart.** 2011. Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00). 2011 (цахим PDF толь).
- Жэнжан.** 2003. 郑张尚芳。上古音系。上海教育出版社,
- Хятад-Монгол толь.** 2007. Гуравдугаар хэвлэл. Эрх. найр. Т.Баатар. ҮХХ.,